

НАГ, Х-1, Д-1, ХН-327

ЦАГДАН СЭРГИЙЛЭХ ГАЗРАА ОЛГОХ ЭРХИЙН ТУХАЙ

Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газраа захирах тушаах дүрэм зааврын ёсоор бага сага хэргийн учир ял торгууль унагах эрх олгох тухай

Аливаа аар саар хэргийг хураангуйгаар хянан үзээд хурдавчлан шийтгэж байваас зохих бөгөөд эдүгээ эрүүгийн хэргүүдийг байцаах шийтгэхүйд дагаж буй нийтийн хууль дүрмээс салгаж авч шийтгэн гүйцэтгэхээр тогтоосон нь:

Нэг. Үүнээс хойш цаазны бичгийн 13, 15, 16, 17, 102, 104, 105, 106, 108, 109, 113, 114, 121, 132 ба 133 дугаар зүйлүүдэд заасан гэмт явдлыг үйлдэгсдийг захирах тушаах дүрмийг баримтлан шийтгэн таслах зэргийг Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газарт эдлүүлбээс зохимуй.

Хоёр. Аливаа хэргийн учир ял торгууль унагах явдлыг цагдан сэргийлэх газрын дарга буюу түүний орлогчоос эрхлэн тогтоож байваас зохимуй.

Гурав. Дээрх нэгдүгээр зүйлд заасан гэмт явдлыг үйлдэгсдийг шийтгэхдээ ангийн бодлого чанарт нийлэлцүүлэн унагах ялын зүйлүүд нь:

1. Ухуулан сэргэмжлүүлэх
2. Гучин төгрөг хүртэл торгох
3. Гучин өдөр хүртэл албадан ажил хийлгэх

Дөрөв. Ухуулан сэргиймжлүүлэхээр тогтоохууд баримтлах учир шалтгаан нь мөнгөөр торгох буюу албадан ажил хийлгэх нь хараахан зүйд үл нийлэлцүүлэх буюу уул үйлдсэн гэмт явдал нь хөнгөн болохын дээр түүний учир нугуудыг үл мэдсэний зэрэг зүйлүүд болмуй.

Тав. Мөнхүү нэгдүгээр зүйлд заасан хэргүүдийн заримыг нь цагдан сэргийлэхээс зохих шүүх таслах газраа шилжүүлэн шийтгүүлж болох үүнд баримтлах учир шалтгаан нь уул хэргийн ял нь энэхүү тогтоолын 3 дугаар зүйлд зааснаас хүнд буюу эсвээс хэрэгтэн хүний зан авир ба үйлдсэн хэргийн байдалд ард олны хамгаалах явдалд гэмхор болох зүйл байхыг харгалзан гүйцэтгэвээс зохимуй.

Торгуулийн зүйлийг цаг тухайд төлөхгүй хүн байх ахул харьяат хотын захиргааны зөвлөлөөс албадан ажил хийлгэх бөгөөд нэгэн төгрөгийг нэгэн өдөрт таацмуй.

Долоо. Албадан ажил хийлгэх тогтоолыг өөрчдөн мөнгөөр ердөө үл болох боловч хэрвээ уул хүний бие өвчин эмгэгтэйн зэрэг зүйтэйд үзэх онц учир шалтгаан байх учраа ажил хийж чадахгүй аваас тийнхүү сольж болмуй.

Найм. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд жагсаасан аар саар хэргүүдийн дотроос ямар нэгийг өдүүлсэн зүйл байх ахул цагдан сэргийлэхээс даруй протокол буюу тогтоол үйлдэж, түүнд хэргийн учрыг товч тодорхойлбоос зохихоос гадна хаана хэзээ уул хэргийг үйлдсэнийг мөн оролцуулан гүйцэтгэмүй.

Ес. Уул тогтоолд түүнийг анх бичсэн хүн ба хэрэгтэн жич гэрчийн этгээд байлцсан аваас даруй тус тусын гарын үсгийг зурж гүйцэтгэвээс зохихооё гадна хэрэгтнээс хэргийн учир шалтгааныг ууд протоколын сүүлд ялган салгаж, илтгэн бичиж болмуй. Хэрвээ уул хэрэгтэн хүн үсэг бичиг мэдэхгүй ахул түүнийг протоколд тэмдэглэхийн дээр түүнээс тайлбарлан мэдүүлэх зүйл байх аваас протоколыг байгуулсан хүн тухайд өөрөө бичиж гүйцэтгэвээс зохимуй.

Арав. Ял торгууль унагах тогтоолыг хурдавчлан үйлдвээс зохих үүнд уул хэргийг үйлдсэн өдрөөс эхлэн бодож хэрхэвч нэгэн сараас хэтрүүлж үл болох ба хэрвээ энэхүү хугацааг алгуурлахууд хүрвээс уул хэргийг хэлэлцэхгүй болговоос зохимуй.

Арван нэг. Аливаа ял торгууль унагаасан тогтоолыг бичгээр үйлдэж, дараагийн гурван хоногийн дотор шийтгэгдсэн этгээдэд олговоос зохимуй.

Арван хоёр. Дээрх зүйлүүдэд заасан ял торгуулийн тогтоолыг харьяат цагдан сэргийлэх газраас даруй гүйцэтгэвээс зохих бөгөөд хэрхэвч уул түүнийг тогтоосон өдрөөс эхлэн нэгэн сараас олгуулахгүйгээр гүйцэтгэн дуусгаваас зохимуй. Хэрвээ уул тогтоолыг байгуулсан өдрөөс эхлэн хоёр сарын дотор гүйцэтгэхийг завдаж чадсангүй ахул түүнийг даруй хүчин төгөлдөр үгүй болсонд тооцвоос зохимуй.

Арван гурав. Зохих газраас шийтгэн тогтоосон торгуулийн зүйлийг уул тогтоолыг шийтгэгдсэн этгээдэд тушаан олгосон өдрөөс эхлэн бодож долоон хоногийн дотор хотын захиргааны газраа төлж, гүйцэтгэвээс зохимуй.

Арван дөрөв. Хэрвээ торгуулийн зүйлийг цаг тухайд төлөхгүй этгээд байх ахул түүний хувийн хөрөнгө хогшил мөнгө зоосын зэрэг үнэ бүхий зүйлүүдийг битүүмжлэн эдүгээ аливаа шүүх таслах, газрын тогтоолыг гүйцэтгэхүйд дагаж хэрэглэж буй хууль ёсоор гүйцэтгэвээс зохимуй.

Аарван тав. Аливаа албатан ажил хийлгэхээр шийтгэгдсэн хүмүүсийг харьяат хотын захиргааны зөвлөлд хүргүүлэн бичиг бодлогоос бусад зохих ажлыг гүйцэтгүүлбээс зохимуй.

Арван зургаа. Аливаа аар саар хэргийн учраа албадан ажил хийлгэхээр шийтгэгдсэн хүмүүсийн дотроос бусдад өөрийн хүчийг үнэлж буй этгээд ахул албадан ажил хийлгэх тухайн хуулийг зохион зарлахын янар \өмнө\ уул хэргийг хотын захиргааны газрын зөвлөлөөс хянан үзээд өөрчлөн мөнгө торгохоор тогтоож болмуй.

Арван долоо. Хэрвээ аливаа шийтгэгдсэн хүнээс гуйж мэдүүлсэн зүйл байх агаад зүйтэйд үзэх учир шалтгаан илэрвээс цагдан сэргийлэх газраас тогтоолыг өөрчдөх буюу бүрмөсөн устган тогтоож болмуй.

Арван найм. Аливаа хэргийн учраа шийтгэгдсэн хүнээс уул ял торгууль унагасан тогтоолыг үл зөвшөөрөн энэхүү тогтоолын 19 дүгээр зүйлийг баримтлан заалдан мэдүүлж болмуй.

Арван ес. Цагдан сэргийлэх газраас шийтгэн гаргасан аливаа хэргийн тогтоолыг үл зөвшөөрөн хотын захиргааны газрын зөвлөлд заалдан мэдүүлснийг уул зөвлөлөөс хэргийн байдалд нийлэлцүүлэн шийтгэхүй нь

1. Ялыг хөнгөтгөх
2. Аливаа нэгэн ял торгуулийн зүйлийг өөрчлөн сольж мөн хөнгөтгөх үүнд энэхүү тогтоолын 6 ба 7 дугаар зүйлүүдийг баримтлан гүйцэтгэвээс зохимуй.
3. Зохих тогтоолыг бүрмөсөн устгаж, цааш гүйцэтгэх явдлыг хэлэлцүүлэхгүй болгох.

Хорь. Хотын захиргааны газрын зөвлөлийн тогтоолууд болбоос бүрмөсөн шийтгэн тасалсан зүйл болох учраа түүнийг үл зөвшөөрөн тэмцэн заалдаж, үл болмуй.

Хорин нэг. Аливаа заалдан мэдүүлэх хэргийг хотын захиргааны газрын зөвлөлд шууд буюу цагдан сэргийлэх газраар уламжлуулсан ахул уул газраас хүлээн авсны дараагийн гурван хоногийн дотор харьяат зөвлөлд хамаг хэргийн хамт хүргүүлбээс зохимуй.

Хорин хоёр. Тийнхүү заалдан мэдүүлсэн хэргийг хотын захиргааны газрын зөвлөлөөс хүлээн авсан өдрөөс эхлэн арван дөрвөн хоногийн дотор шийтгэн тасалбаас зохимуй.

Хорин гурав. Аливаа заалдан мэдүүлэх хэргийг цагдан сэргийлэх газраас ял шийтгэсэн тогтоолыг зохих сэжигтэн этгээдэд олгосон өдрөөс эхлэн долоон хоногийн дотроо мэдүүлбээс зохих бөгөөд хэрвээ уул хугацаанаа мэдүүлсэн ахул тухайн тогтоолыг гүйцэтгэх явдлыг түтгэлзүүлбээс зохихын дээр уул хугацааг алгуурласан зүйл байх ахул хянаж хэлэлцэх явдалгүй болмуй.

Хорин дөрөв. Дээрх зүйлүүдэд заасан хэрэг явуулгыг харьяат цагдан сэргийлэхээс хэрхэн гүйцэтгэж буйг хянаж, удирдах эрхийг шүүх явдлын яаманд эдлүүлбээс зохиоос гадна хэрвээ учир шалтгаан байх ахул уул яамнаа тухайд энэхүү тогтоолыг ёсоор гүйцэтгэхүйд дагаж хэрэглэх дүрэм зааврыг шийтгэн гаргаваас зохимуй.

Хорин тав. Цагдан сэргийлэх газар ба хотын захиргааны газрын зөвлөлөөс аливаа хэргийн учраа шийтгэн гаргасан тогтоолыг шүүх явдлын яамнаас хянан үзэх ба үл зөвшөөрөн татгалзах эрхийг эдлэх бөгөөд уул цагдан сэргийлэх газар буюу зөвлөлд дахин хянах шийтгэхийн тулд тушаасан түүнийг тэдгээр газар буюу зөвлөлөөс ёсоор дагаж гүйцэтгэхгүй ахул даруй мөнхүү яамнаас улсын дээд эрхийг барих засгийн газар ба улсын бага хурлын тэргүүлэгчдэд хүртэл мэдүүлж болмуй.

Хорин зургаа. Шүүх явдлын яамнаас дотоод явдлын яам лугаа харилцан тогтоож тухайд засгийн газраа мэдүүлж энэхүү тогтоолыг бусдад дагаж хэрэглэж болмуй.